

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  
БАЯНДАЛАЙН САРАНГЭРЭЛИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
<b>Зорилт 1. “Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох”</b>							
1	Арга хэмжээ 1.1. Салбарын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, хэм хэмжээний акт, норм ба дүрэм, стандартад болон холбогдох төсөлд санал хүргүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Дээд шатны байгууллагаас ирүүлсэн дараах хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төсөл, дүрэм журамд санал боловсруулж, хүргүүлэв. Үүнд: - Барилгын ерөнхий хуулийн төсөл; - Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл; - Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл; - Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; - Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль; - Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрэм; - Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам; - Бусад.	2025.01.02- 2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>Түүнчлэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд салбарын чиг үүрэгт хамаарах дараах дүрэм журам, албан бичиг, нөлөөллийн шинжилгээг боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэв. Үүнд:</p> <p>-Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/1227 дугаартай албан бичгээр “Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын ажиллах зардлын жишиг хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэмжээг харгалзан тогтоох тухай” албан бичиг боловсруулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад;</p> <p>-“Барилгын үйл ажиллагааны аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ын нөлөөллийн шинжилгээг боловсруулж, НЗДТГ-т;</p> <p>-Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж,  <a href="https://www.inspection.ub.gov.mn/post-page?id=117">https://www.inspection.ub.gov.mn/post-page?id=117</a> сайтад байршуулсан.</p>		
2	<p>Арга хэмжээ 1.2.  Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг ижил түвшний эрх зүйн тогтолцоо бүхий улс орны хяналтын тогтолцоотой харьцуулсан судалгаа хийх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-	30	<p>Тус судалгаатай холбоотойгоор Герман, Япон, Швейцарь, Сингапур, Өмнөд Солонгос, Норвеги, Австрали, Бүгд Найрамдах Хорват зэрэг улсуудын барилгын хяналтын тогтолцоог ерөнхий чиглэлийн хүрээнд судалсан. Тус судалгааны хүрээнд Монгол Улсын төрийн хяналт шалгалтын эрх орчныг Ром-Германы эрх зүйн бүл бүхий дараах улс орны эрх зүйн орчинтой харьцуулсан судалгааг хийсэн. Үүнд:</p>	<p>2025.01.02- 2025.11.24</p>	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>-Бүгд Найрамдах Солонгос Улсын төрийн хяналт, барилгын хяналтын тогтолцоо, эрх зүйн орчин-Аудит болон хяналт шалгалтын тухай хууль (Board of Audit and Inspection Act), Барилгын хууль (Building act)</p> <p>-Бүгд Найрамдах Словень улсын төрийн хяналт шалгалтын тогтолцоо, эрх зүйн орчин- Хяналт шалгалтын тухай хууль (Inspection act of Slovenia)</p>		
3	<p>Арга хэмжээ 1.3. Хяналт шалгалтын үр дүн, үр нөлөөг сайжруулах хүрээнд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж, уламжлах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-	50	<p>Тус арга хэмжээний дагуу дараах саналыг боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 сарын 04-ний өдрийн А/1459 дүгээр захирамжаар батлагдсан "Хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах санал зөвлөмж боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох 6 хууль тогтоомжийн 24 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулгын хамт боловсруулж 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/186 дугаартай албан бичгээр НЗД-д;</li> <li>- Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор "Нийслэлийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг баталж, тус газрын удирдлага нь ахлагчаар томилогдсон. Тус ажлын хэсгийн дагуу 8 хууль тогтоомжийн 36 зүйл, заалтад</li> </ul>	2025.01.02-2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/890 дугаартай албан бичгээр НИТХ-д, 01/891 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлсэн.</p> <p>(Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Барилгын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам, Засгийн газрын 212 дугаар тогтоолоор баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм)</p>		
4	<p>Арга хэмжээ 1.4. Барилга, дэд бүтцийн болон бусад салбарын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийг боловсруулж, дээд шатны байгууллагад уламжлах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-	90	<p>Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хэлэлцүүлэв.</p>	<p>2025.01.02- 2025.11.24</p>	100%
5	<p>Арга хэмжээ 1.5. Нийслэлийн хэмжээнд мөрдөгдөх “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргад өргөн мэдүүлэх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-	90	<p>Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдах “Нийслэл дэх барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ыг хууль тогтоомжийн дагуу хянан нийцүүлэлт хийж, нөлөөллийн шинжилгээний хамт 2025 оны 3 дугаар сарын 24-ний 01/242 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.</p>	<p>2025.01.02- 2025.11.24</p>	100%
6	<p>Арга хэмжээ 1.6. Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дотоод дүрэм, журмыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-	50	<p>1.Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг төслийн шатанд хууль тогтоомжид нийцүүлэн хяналт хийж, санал тусгасан ба хариуцлага бүлгийг бүхэлд нь зассан.</p>	<p>2025.01.02- 2025.11.24</p>	100%

	1	2	3	4	5	6	7
					2.Захиргааны шийдвэрийг үндэслэл бүхий боловсруулах, шийдвэр гаргах ажиллагааны журмыг баримтлах хүрээнд байгууллагын хэмжээнд мөрдөгдөх “Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг шинэчлэн боловсруулав.		
<b>Зорилт 2. “Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох ажиллагааг зохион байгуулна”</b>							
7	Арга хэмжээ 2.1. Байгууллагад ирсэн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу хөтөлж, судалгааг прокурорын байгууллагад хугацаанд нь хүргүүлж байгаа эсэхэд хяналт тавих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтний орон тоо сул байгаа тул Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн 138 бүртгэлийг 2025 оны 06 сарын 20-ныг хүртэл прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хууль тогтоомжийн дагуу хяналт тавин ажиллав.	2025.01.02- 2025.11.24	100%
8	Арга хэмжээ 2.2. Байгууллагын албан хаагчдад эрх зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Албан хаагч, эрх бүхий албан тушаалтнуудад үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд тухай бүр хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүнд: -барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа; - -зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа; -Хүний нөөц хариуцсан албан хаагчид тушаал, шийдвэр боловсруулах болон Дотоод хяналт, шинжилгээний хэлтэст дээд шатны байгууллагаас болон хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн гомдол шийдвэрлүүлэх үйл ажиллагаа; -компанийн эрх зүй, төлөөлөл; -зөвшөөрөлгүй, удаа дараа гомдол ирүүлдэг, маргаантай барилга, объектын талаар. Түүнчлэн байгууллагын нийт албан хаагчдад дараах сургалтыг зохион байгуулж, эрх зүйн мэдээллээр хангав. Үүнд:	2025.01.02- 2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
					<ul style="list-style-type: none"> <li>- 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр “Хяналт шалгалтын эрх зүйн орчин ба сайжруулах хэрэгцээ, шаардлага;</li> <li>- 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг”;</li> <li>- 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, анхаарах асуудал” сэдэвт сургалт;</li> <li>- 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигаас урьдчилан сэргийлэх нь: Анхаарах асуудал” сэдэвт сургалт.</li> </ul>		
<b>Зорилт 3. “Үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн удирдлагад хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хууль, шүүхийн өмнө төлөөлөх”</b>							
9	<p>Арга хэмжээ 3.1. Хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг дарга, газрын удирдлагыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг Нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	<p>Хариуцсан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлж 16 хэрэг маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хууль тогтоомжийн дагуу төлөөлөн оролцсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүрэн цутгамал ХХК;</li> <li>- Иргэн Р.Адъяасүрэн;</li> <li>- Юу ди трэйд ХХК;</li> <li>- Хүчит чулуут ХХК;</li> <li>- Паркнайн ХХК;</li> <li>- Монгол Угсаа Констракшн ХХК;</li> <li>- Ломекс ХХК;</li> <li>- Ач очир ХХК;</li> <li>- Эрчим СӨХ;</li> <li>- Эм ти эс ХХК;</li> <li>- Д.Ундрахсан С.Базарваань нар;</li> <li>- Иргэн Баттогтох;</li> <li>- Монос Хүнс ХХК;</li> <li>- Баганат ергөө ХХК;</li> </ul>	2025.01.02- 2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
					<ul style="list-style-type: none"> <li>- Иргэн Даваадолгор;</li> <li>- Иргэн Баасандорж.</li> </ul> Үүнээс, -Бүрэн шийдвэрлэгдсэн: 9 маргаан буюу 56.25%; -Хэрэг хянан шийдвэрлэгдэх шатанд хэлэлцэгдэж байгаа: 7 маргаан буюу 43.75%; Шийдвэрлэгдсэн байдлаас авч үзвэл, -Нэхэмжлэгчийн талд шийдвэрлэсэн: 4 буюу 44.4%; -Хариуцагчийн талд шийдвэрлэсэн: 5 маргаан буюу 55.5%.		
<b>Зорилт 4. “Төрийн байгууллагын дотоод засаглалын үйл ажиллагааг тогтмол сайжруулах, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх”</b>							
10	Арга хэмжээ 4.1. Газрын үйл ажиллагаатай холбоотой гэрээ, эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	-Албан хаагчдын үндсэн чиг үүргийн хүрээнд боловсруулсан нийт 103 А тушаал, 129 Б тушаал, нийт 232 тушаалын хуулийн үндэслэх хэсгийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэв. -Байгууллагын нэрийн өмнөөс баталж буй хамтран ажиллах, худалдах, худалдан авах тухай 18 гэрээг иргэний хууль тогтоомжийн дагуу хянав.	2025.01.02- 2025.11.24	100%
<b>Зорилт 5. “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”</b>							
11	Арга хэмжээ 5.1. ХАСХОМ (Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг)-ийг мэдүүлэх эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Хуульд заасны дагуу 2024 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг холбогдох хууль тогтоомжийн хугацаанд <a href="https://mediuleg.iaac.mn">https://mediuleg.iaac.mn</a> цахим системд тайлагнаж, баталгааны маягтийг 2025 оны 02 сарын 01-ний өдөр эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.	2025.01.02- 2025.11.24	100%
12	Арга хэмжээ 5.2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн мэдээллийг	Сард тайлагнах давтамж	1	1	Хууль тогтоомжийн дагуу газрын даргын 2025 оны “Шилэн дансанд мэдээлэл оруулах албан хаагчдын жагсаалт”-ын дагуу “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай	2025.01.02- 2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
	<a href="https://shilendans.gov.mn/">https://shilendans.gov.mn/</a> цахим системд тухай бүр тайлагнах				мэдэгдэл"-ийг сар бүр цахим системд бүртгэн ажиллав.		
13	Арга хэмжээ 5.3. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг бүрэн хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын батлах “Авлигын эсрэг төлөвлөгөө”-г 3 зорилт 17 арга хэмжээ боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр батлуулсан бөгөөд төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хэрэгжүүлж (95,8%), 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/575 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлэв. Түүнчлэн “Эрх зүйн актад тавих хяналтыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” газрын даргын чиглэлийг боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр батлуулав.	2025.01.02- 2025.11.24	100%
14	Арга хэмжээ 5.4. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулна	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	1.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд дараах сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулав. Үүнд: - Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан “Нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэрэг”-т оногдуулах ялын хэмжээ чангарсан талаар 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлигын гэмт хэрэг” сэдвээр нийт албан хаагчдад мэдээллийн цаг зохион байгуулав. - Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигаас урьдчилан сэргийлэх нь: Анхаарах асуудал” сэдвээр нийт албан хаагчдад 2025	2025.01.02- 2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>оны 09 дүгээр сарын 04-ний өдөр мэдээллийн цаг зохион байгуулсан.</p> <p>2.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 2 тв шторк, 5 зурагт хуудас, 7 мэдээ, мэдээллийг лэп дэлгэц, байгууллагын мэдээллийн самбар, вэб сайт, пэйж хуудас зэрэгт байршуулан иргэд олон нийтэд тухай бүр мэдээллийг хүргэн ажиллав.</p> <p>3.Авлигын эсрэг “НЭГДЬЕ” аяныг 05 сарын 02-ны өдөр зохион байгуулж, үйл ажиллагааны талаарх мэдээллийг вэб сайт, ирп систем, пэйж хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчлан ажилласан.</p> <p>4.Өөрийн байгууллагын онцлогт тохирсон дараах хэвлэмэл хуудас, сурталчилгааны материалыг мэдээллийн самбар, вэб сайт, пэйж хуудас зэрэгт байршуулан иргэд олон нийтэд авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тогтмол мэдээлэн ажиллав.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Бод, нягтал, тэгээд татгалз” уриатай зурагт хуудас, сурталчилгааны материал 50 ш;</li> <li>- “Шударга ёс, хөгжил дэвшилд хүргэх 110” мэдээллийн хэвлэмэл хуудас 50ш.</li> </ul>		
15	<p>Арга хэмжээ 5.5.</p> <p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-	100	<p>1.Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2025 оны “Авлигын эсрэг төлөвлөгөө”-ний дагуу авлигын эрсдэлийг бууруулах, барилга, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллагуудтай хамтран</p>	<p>2025.01.02-2025.11.24</p>	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>“Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоо” сэдэвт хэлэлцүүлгийг 04 сарын 16-ны өдөр тус газраас зохион байгуулж, 200 гаруй төлөөлөл оролцсон.</p> <p>Хэлэлцүүлгийн санал, дүгнэлтэд үндэслэн барилгын салбарт оролцогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, 12 дугаар сарын 04-ний өдөр Авлигатай тэмцэх газар, улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа байгууллагууд болон барилгын салбарын хувийн хэвшлүүд зэрэг 40 гаруй байгууллагын төлөөлөл оролцон дүрмийн төсөлд санал, дүгнэлтээ тусгасан.</p>		
16	Арга хэмжээ 5.6. ХАСХОМ (Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг)-ийг мэдүүлэх эрх бүхий албан хаагчдаас шинэчлэн болон шинээр авах, хяналт тавих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	72	55	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын 48 мэдүүлгийг албан хаагчдаар гаргуулж, хяналт тавин ажиллав.	2025.01.02- 2025.11.24	100%
17	Арга хэмжээ 5.7. Шинээр нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн албан хаагчдаас ХАСУМ (Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг)-ийг хүлээн авч баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Шинээр болон албан үүрэг хавсран гүйцэтгэх, шилжин ажиллахаар нэр дэвшсэн 24 албан хаагчийн ХАСУМ (Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг)-ийг хүлээн авч баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажиллав.	2025.01.02- 2025.11.24	100%
<b>Зорилт 6. “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх”</b>							

	1	2	3	4	5	6	7
18	Арга хэмжээ 6.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	1.Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Нийслэлийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг баталж, тус газрын удирдлага нь ахлагчаар томилогдсон. Тус ажлын хэсгийн дагуу 10 дэд ажлын хэсэг байгуулагдаж, “2.Нийслэлийн хяналт шалгалтын хууль, эрх зүйн орчинд судалгаа, шинжилгээ хийж, саналыг нэгтгэн боловсруулах” ажлын хэсгийн хүрээнд 8 хууль тогтоомжийн 36 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/890 дугаартай албан бичгээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд, 01/891 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлсэн.	2025.01.02-2025.11.24	100%
<b>Зорилт 7. “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, хэм хэмжээг мөрдлөг болгох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ”</b>							
19	Арга хэмжээ 7.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн шаардлага, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хэм хэмжээ”-г мөрдлөг болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хэм хэмжээ”-г мөрдлөг болгон, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллаж байна.	2025.01.02-2025.11.24	100%
<b>Зорилт 8. “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, стандартыг мөрдлөг болгоно”</b>							
20	Арга хэмжээ 8.1. Байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хувь	-	100	2025 оны байдлаар дээд шатны байгууллага болон холбогдох хууль хяналтын байгууллага, иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 90 албан бичгийг хууль	2025.01.02-2025.11.24	100%

1	2	3	4	5	6	7
сайжруулж, зөрчил үүсгэхгүй ажиллах				тогтоомжийн дагуу зөрчил гаргахгүйгээр шийдвэрлэсэн байна.		

### Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх, зохион байгуулах үйл ажиллагаанд дараах байдлаар ажиллав. Үүнд: -Гадаад харилцааг өргөжүүлэх, хөгжүүлэх зорилгоор нийт 14 албан бичиг, 1 хөтөлбөр, 3 А тушаал, 9 ажил байдлын тодорхойлолт боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. -Албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-ы Хөх хот, Хонконг Улсын холбогдох байгууллагын мэргэжилтнүүдтэй харилцаа, холбоо тогтоож ажиллав.	2025.01.02-2025.11.24	100%
2	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Хүний нөөцийн бодлого тодорхойлох, шийдвэр боловсруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	1.Бүтэц, орон тоог боловсронгуй болгох: - “20 минутын хот” концепцитай уялдуулан байгууллагын бүтэц, орон тооны саналыг удирдлагад танилцуулж, судалгаа, шинжилгээний хамт 2025 оны 05 сарын 12-нд НЗДТГ-т хүргүүлэв. - Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01, 03 дугаар албан даалгавар, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд, бүтэц, орон тооны санал, танилцуулгыг бэлтгэж, 2025 оны 09 сарын 30-ны 01/951 дугаартай албан бичгээр НЗДТГ-т; - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаас ирүүлсэн	2025.01.02-2025.11.24	100%

					<p>чиглэлийн дагуу байгууллагын бүтэц, орон тооны саналыг боловсруулж, 2025 оны 09 сарын 12-ны 01/895 дугаартай албан бичгээр НЗДТГ-т тус тус хүргүүлсэн.</p> <p>- Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор “Албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” тушаалын төслийг боловсруулж, 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлуулав</p> <p>2.Тушаал, шийдвэр боловсруулах: Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотойгоор нийт 10 А, 18 Б тушаал боловсруулав. (Архивын үзлэгтэй холбоотойгоор 39 Б тушаалыг засварлаж, батлуулсан)</p> <p>3.2 улсын байцаагчийн эрх олгуулах тухай албан бичгийг боловсруулж, хавсралт материалын хамт холбогдох яаманд хүргүүлэв.</p> <p>4.Газрын даргын 2025 оны 06 сарын 05-ны өдрийн А/51 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний баг”-ийн нарийн бичгийн дарга хийж, 42 албан хаагчийн үнэлгээг албажуулан урамшуулал олгуулсан.</p> <p>5. Бусад</p>		
3	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтний албан үүргийг гүйцэтгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	<p>1.Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн 138 бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу 2025 оны 06 сарын хөтөлж, нийслэлийн Прокурорын газрын <a href="mailto:niislelprozurchil@gmail.com">niislelprozurchil@gmail.com</a> цахим хаягаар хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллав. Үүнээс,</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 115;</li> <li>• Зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн 13;</li> <li>• Байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн 6;</li> <li>• Татгалзаж шийдвэрлэсэн 4 бүртгэл байна.</li> </ul>	2025.01.02-2025.11.24	100%

4	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг"-т бэлтгэл ажлыг хангуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Архивын улсын үзлэгт бэлтгэн "Байгууллагын архивын үйл ажиллагааг баримтжуулсан байдал", "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт" дэд хэсгийг шалгуур үзүүлэлтийн дагуу хэлтсийн албан хаагчдын хамт бэлтгэж, 2025 оны 10 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд хамгаалсан.	2025.01.02-2025.11.24	100%
---	--	---------------------------------	---	-----	---	-----------------------	------

### Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад хамрагдах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Тус сургалтад эхний хагас жилд Хүний нөөцийн албан хаагчийн орон тоо сул байсан шалтгаанаар тус сургалтад хамрагдаагүй. Мөн сүүлийн хагас жилд төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгтэй давхцсан тул сургалтад хамрагдаж амжаагүй болно.	2025.01.02-2025.11.24	-
2	Арга хэмжээ 2. Мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ сайжруулан идэвх санаачилгатай ажиллах, дээд шатны байгууллагаас болон газрын хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээ, сургалтад бүрэн хамрагдах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх зорилгоор дараах сургалтад хамрагдав. Үүнд: -Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Батбаяр&Партнерс өмгөөллийн фирмээс зохион байгуулсан "Фидикийн гэрээ"-ний сургалтад 03 дугаар сарын 30-аас 04 дүгээр сарын 01-ний өдөр; -"Бизнес ба хүний эрх" сэдэвт цахим сургалтад 05 дугаар сарын 22-ны өдөр; -Нийслэлийн Прокурорын газраас зохион байгуулсан "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр; -Азийн хуульчдын 13 дахь "Про боно" чуулга уулзалтад 35 улсын 200 гаруй	2025.01.02-2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>хуульчдын хамт 2025 оны 10 дугаар сарын 03-05-ны хооронд;</p> <p>-Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн ИТХ-аас батлан гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг сурталчлан таниулах, албан хаагчдыг чадавжуулах хүрээнд хуулийн асуудал хариуцсан алба хаагчдын дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, арга хэмжээнд 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр;</p> <p>-Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Авлигын эсрэг сургагч багш бэлтгэх сургалтад 2025 оны 12 дугаар сарын 01-02-ны хооронд тус тус хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлээ.</p>		

**ХЯНАСАН:**  
 ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
 ДАРГА  
 ( Албан тушаал )



..... /Б.БАЙГАЛМАА/  
 ( Нэр, гарын үсэг )

2025.12.08  
 ( Огноо )

**ТАЙЛАН ГАРГАСАН:**  
 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН АХЛАХ  
 МЭРГЭЖИЛТЭН  
 ( Албан тушаал )

..... /Б.САРАНГЭРЭЛ/  
 ( Нэр, гарын үсэг )

2025.12.08  
 ( Огноо )

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН МАНДАХЫН ГАЧМААГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
<b>Зорилт 1. Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна. /НХТЖҮЧ-9.5.3/</b>							
1	<b>Арга хэмжээ 1.1.</b> Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлж хамтран оролцох, тайлагнах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Нийслэлийн иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах, хотын стандарт, нормыг мөрдүүлэх хүрээнд 2025 оны эхний хагас жилийн хугацаанд хийгдсэн ажлын биелэлтийг газрын даргаар албажуулан, 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. Мөн арга хэмжээний хэрэгжилтийг өссөн дүнгээр нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/612 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	2025.01.02-2025.11.24	100%
<b>Зорилт 2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, Засгийн газрын сайдуудтай хийх гэрээ, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, газрын даргын үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн тайлагнах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.</b>							
2	<b>Арга хэмжээ 2.1.</b> Байгууллагын үндсэн чиг үүрэгт холбогдолтой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	2025 оны байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбогдох нийт 30 тогтоол шийдвэрийн 62 заалтыг хяналтад авч ажилласан байна. Хяналтад авсан	2025.01.02-2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
	заалтын хэрэгжилтийг нэгтгэх, биелэлтийг хугацаанд нь тайлагнах				заалтын хэрэгжилтийг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тогтоосон хугацаанд нь тайлагнаж, нийт 11 удаагийн тайлан илгээсэн байна.		
3	<b>Арга хэмжээ 2.2.</b> Улс, нийслэлийг хөгжүүлэх богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг хугацаанд нь тайлагнах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	<p>1. “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан 2 зорилт, арга хэмжээний дундаж 50 хувьтай хэрэгжиж, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнасан.</p> <p>2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 3 арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг холбогдох баримтын хамт</p> <p>3. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийг өссөн дүнгээр нэгтгэж, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлтийн хамт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/612 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.</p> <p>4. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2025 оны наймдугаар сарын байдлаар нэгтгэн, нотлох баримтын хамт 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдөр 01/768 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.</p>	2025.01.02-2025.11.24	100%
4	<b>Арга хэмжээ 2.3.</b> Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Монгол Улсын Засгийн газрын гишүүд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд	2025.01.02-2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
	Захирагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээний газрын чиг үүрэгт хамаарах зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, хугацаанд нь тайлагнах				<p>байгуулсан хамтран ажиллах дараах 6 гэрээний хүрээнд байгууллагын эрхлэх асуудал, чиг үүрэгтэй уялдуулан нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/17 дугаар тушаалаар батлуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга- 2 арга хэмжээ;</li> <li>2. Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо- 2 арга хэмжээ;</li> <li>3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд- 1 арга хэмжээ;</li> <li>4. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд- 6 арга хэмжээ;</li> <li>5. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд- 3 арга хэмжээ;</li> <li>6. Эрчим хүчний сайд- 5 арга хэмжээ.</li> </ol> <p>Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар тайлагнаж ажиллав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай байгуулсан гэрээний эхний хагас жилийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр НЗДТГ-т цахимаар хүргүүлсэн.</li> <li>➤ Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргатай байгуулсан гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/535 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.</li> <li>➤ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний</li> </ul>		

	1	2	3	4	5	6	7
					<p>өдрийн 01/1163 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.</p> <p>➤ Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1164 дугаартай НЗДТГ-ын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.</p>		
5	<p><b>Арга хэмжээ 2.4.</b> Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын биелэлтийг хангуулах, шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, тухай бүр заагдсан хугацаанд тайлагнах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-	100	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 онд баталсан нийт 14 захирамж, 1 албан даалгавар, шуурхай хуралдаанаас өгсөн 43 үүрэг даалгаврыг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажиллаж, тухай бүр заагдсан хугацаанд тайлагнаж ажилласан.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан болон бусад захирамжуудын хэрэгжилтийг заагдсан хугацаанд тайлагнаж, нийт 7 удаагийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 22 удаа зохион байгуулагдаж, газрын чиг үүрэгт хамаарах нийт 81 үүрэг даалгавар (үндсэн хэрэгжүүлэх 28/) өгөгдөн, 93,1 хувьтай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг удирдлагаар баталгаажуулан ERP-Хяналт шинжилгээ үнэлгээ дэд системээр тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан. Мөн 2025 оны 1 дүгээр сараас хойш Нийслэлийн шуурхай хуралдаанаар өгөгдсөн нийт</p>	2025.01.02-2025.11.24	100%

	1	2	3	4	5	6	7
					<p>21 үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс 2024 онд өгсөн 1 үүрэг даалгавар, 2025 онд өгсөн 41, нийт 42 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн ДХШХ-ийн даргаар баталгаажуулж, 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнасан.</p> <p>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр дүүрэг, хороодын Засаг дарга нартай хийсэн ээлжит 03 дахь уулзалтаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 01/1037 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан.</p>		
6	<p><b>Арга хэмжээ 2.5.</b> Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1024 дүгээр захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс хариуцсан чиг үүргийн дагуу индексийн үзүүлэлтийг үйл ажиллагаандаа уялдуулж, сайжруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>		50	<p>Хотын хөгжлийн индексийн 86 үзүүлэлтээс байгууллагын чиг үүрэгтэй уялдах 6 үзүүлэлтийг тодорхойлон, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгасан.</p>	<p>2025.01.02-2025.03.14</p>	90%
7	<p><b>Арга хэмжээ 2.6.</b> Газрын үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулах асуудлын саналыг хүргүүлж, хуралдааны</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	-	70	<p>Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд дараах 3 асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж, саналыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын</p>	<p>2025.01.02-2025.11.24</p>	100%

	1	2	3	4	5	6	7
	тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах				<p>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны асуудал хариуцсан мэргэжилтэн М.Энхжаргалд цаасаар болон цахимаар хүргүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналт шалгалтын дүнгийн тухай танилцуулга;</li> <li>2. Хот байгуулалт, барилга, дэд бүтэц, орчны аюулгүй байдлыг хангуулах, хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартыг мөрдүүлэх чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын үр дүн, цаашид авах арга хэмжээ;</li> <li>3. Барилга байгууламж, барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааны танилцуулга.</li> </ol> <p>Мөн дээрх асуудлуудаас гадна 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдаанаар “Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр”-ийн төслийг танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01, 04 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн 4 үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн 4 үүрэг даалгавар, 07 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн 5 үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-ын</p>		

	1	2	3	4	5	6	7
					Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн.		
8	<b>Арга хэмжээ 2.7.</b> Хяналт шалгалтын газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөөг тухай бүр батлуулах, зохион байгуулах, үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	Хэлэлцэх асуудал, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, хувь	-	100	Хяналт шалгалтын газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурал 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдаж, 4 асуудал хэлэлцсэн.	2025.03.00- 2025.03.13	100%
9	<b>Арга хэмжээ 2.8.</b> Хяналт шалгалтын газрын даргын шуурхай хуралдааныг зохион байгуулах, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнах	Хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, хувь	-	100	Газрын даргын шуурхай хуралдааныг 22 удаа зохион байгуулж, нийт 270 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүрэг даалгаврын биелэлтийн дундаж 85.3 хувийн хэрэгжилттэй байна. Мөн 2025 оны 1 дүгээр сараас хойш өгсөн бүх үүрэг даалгаврын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа үүрэг даалгаврын талаарх мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр даргын шуурхай хурлаар танилцуулсан.	2025.01.13- 2025.11.24	90%
<b>Зорилт 3. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, стандартыг мөрдлөг болгоно.</b>							
10	<b>Арга хэмжээ 3.1.</b> Байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулж, зөрчил үүсгэхгүй ажиллах	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хувь	-	100	Тайлант хугацаанд нийт 48 албан бичиг хүлээн авснаас 44 албан бичгийг судлан шийдвэрлэж, 4 албан бичгийг судалж байна. Шийдвэрлэлтийн явцад зөрчил дутагдал гаргаагүй болно.	2025.01.13- 2025.11.24	100%
<b>Зорилт 4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, хэм хэмжээг мөрдлөг болгох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>							

	1	2	3	4	5	6	7
